


Хичээлд бүртгүүлэлт (баталгаажуулалт)-ын заавар

Гарчиг

Хичээлд бүртгүүлэлт (баталгаажуулалт).....	3
Нүүр хуудас	3
Хичээл баталгаажуулалт	4
1-р хэсэг. Төлөвлөсөн хичээлийн жагсаалтаас хуваарь сонгох	5
2-р хэсэг. Хуваарь сонгосон хичээлийг баталгаажуулах, цуцлах	7
2.1 Баталгаажуулах хичээлийг сонгох	8
2.2 Төлбөр төлөх хэлбэр сонгох.....	9
3-р хэсэг. Хичээл амжилттай баталгаажсан эсэхийг шалгах	13
Урьдчилан хуваарь харах	14


Хичээлд бүртгүүлэлт (баталгаажуулалт)

Та нэгдсэн хандалтын орчны нүүр хэсэгт байрлах **SISi (шинэ) хичээл бүртгүүлэлт /баталгаажуулалт/** хэсэгт дарж баталгаажуулах хуудсанд шилжинэ.




Нүүр хуудас

SISi суралцагчийн мэдээллийн системийн нүүр хуудсанаас суралцагчийн ерөнхий мэдээлэл, тухайн улиралд судалж буй хичээлүүд, мэдээ мэдээлэл, гарын авлага зэрэг хэсгүүдийг харж болно.




Хичээл баталгаажуулалт

Баталгаажуулах цэсийг дарснаар Хуваарь сонгох хэсэг гарч ирэх бөгөөд дараах хэсгүүдээс бүрдэнэ.



- Хичээл сонголт хуудсанд байрлах **Төлөвлөгөө** хэсэгт суралцагчийн суралцаж байгаа үндсэн төлөвлөгөө харагдана. Хэрэв **хос, хавсарга** хөтөлбөрөөр зэрэг суралцаж байгаа бол хичээл сонголт хийх гэж буй сургалтын төлөвлөгөөг сонгох шаардлагатай.

МУИС, ШУС-ийн хичээлд бүртгүүлэлт (Баталгаажуулалт) 2022-01-11 16:00:00-с 2022-01-24 13:00:00 -ны хооронд явагдана.




- Хичээлүүд нь сонгосон байдлаас хамаарч дараах хэсгүүдэд харагдана.

1. Төлөвлөсөн	2. Сонгосон	3. Баталгаажуулсан
Хувийн төлөвлөгөөн дэх тухайн улиралд судлахаар төлөвлөсөн хичээлийн жагсаалт	төлөвлөсөн хичээлийн хуваариас сонгосон баталгаажуулахад бэлэн болсон хичээлийн жагсаалт	хуваарь сонгосон хичээлийн төлбөрийг төлж баталгаажуулсан хичээлийн жагсаалт

Хичээл баталгаажуулалт нь 3 хэсэгтэй. Үүнд:

- Төлөвлөсөн хичээлийн жагсаалтаас хуваарь сонгох
- Хуваарь сонгосон хичээлийг баталгаажуулах, цуцлах
 - Баталгаажуулах буюу төлбөр төлөх
- Баталгаажуулалтын хянах, цуцлах






Хэсэг тус бүрийн зааврыг харгалзах бүлгээс харна уу.

1-р хэсэг. Төлөвлөсөн хичээлийн жагсаалтаас хуваарь сонгох

Төлөвлөсөн хэсэгт суралцагчийн хувийн суралцах төлөвлөгөөний тухайн улиралд судлахаар оруулсан хичээлийн жагсаалт харагдана. Сонгох боломжтой хичээлүүд дээр **сонгох** товч харагдах бөгөөд хичээлийн нэр дээр дарж хичээлийн мэдээлэлтэй танилцаж болно.



Сонгох товч харагдахгүй бол тухайн хичээлийн хуваарь бэлэн биш байгаа бөгөөд харгалзах тайлбар бичигдсэн байна.

GENE306 Генийн ба эсийн инженерчлэл 3 бц

⚠ Хичээлийн хуваарь бэлэн биш.

Байгалийн ухааны салбар-ийн хичээлийн **Хичээл зохицуулалт хариуцсан мэргэжилтэнд** хандана уу.

GENE306 Генийн ба эсийн инженерчлэл 3 бц

⚠ Судлах боломжгүй.

Өмнөх уялдаатай хичээл үзээгүй байна.

Хэрэв тухайн хичээлийн хуваарийн суудлын тоонд багтахгүй бол хүлээлгийн жагсаалтанд бүртгүүлж болно. Хүлээлгийн жагсаалтанд байгаа суралцагч тухайн хичээл дээр сул суудал гарвал хүлээлгийн жагсаалтын дарааллын дагуу бүртгүүлэх боломжтой болно. Хүлээлгийн жагсаалтад орсон тохиолдолд дараах байдлаар харагдана.

GENE306 Генийн ба эсийн инженерчлэл 3 бц

☰ Та хүлээлгийн жагсаалтны 54-р байранд байна.

Төлөвлөсөн хэсэгт байрлах хичээлүүдээс сонгох боломжой хичээлийн **Сонгох** товчийг дарж тухайн хичээлд тавигдсан хичээлийн хуваарийг харах, сонгох үйлдэл хийнэ.

Хуваарь сонгох

Лекц

- 14/128 Дав 16:00 - 17:30 Алтанчимэг.Э Хичээлийн байр 4-221
- 6/151 Дав 16:00 - 17:30 Уянга.Г Хичээлийн байр 5-605
- 3/76 Мян 11:00 - 12:30 Алтанчимэг.Э Хичээлийн байр 4-1

Семинар

- 0/31 Лха 09:20 - 10:50 Алтанчимэг.Э Хичээлийн байр 4-205
- 6/32 Лха 11:00 - 12:30 Алтанчимэг.Э -Хич ИҮ байр 221 лекцийн заал Хичээлийн байр 4-2166
- 6/30 Мян 07:40 - 09:10 Анар.П Хичээлийн байр 4-2166
- 2/35 Баа 14:20 - 15:50 Анар.П Хичээлийн байр 4-2166

Сонгох

Дарах

Хаах Сонгох

Лекцийн хуваарийг сонгоход тухайн лекцэнд харгалзах лаборатори эсвэл семинар автоматаар гарч ирэх (*лекцгүй хичээл бол бусад хэлбэрээс эхэлнэ*) ба хуваариудаа бүрэн сонгосны дараа **Сонгох** товчийг даран сонгоно.

Санамж:

- Хичээлийн хуваарийг Элсэлт бүртгэлийн хэлтсийн хичээл зохицуулалт хариуцсан мэргэжилтэн (бүрэлдэхүүн сургууль) тавьдаг тул хуваарьтай холбоотой асуудлаар холбогдох мэргэжилтэнд хандана. [Энд](#) дарж элсэлт бүртгэлийн хэлтсийг сонгон холбогдох мэдээллийг харна уу.

2-р хэсэг. Хуваарь сонгосон хичээлийг баталгаажуулах, цуцлах

Сонгосон хэсэгт хичээлийн хуваарь сонгосон баталгаажуулахад бэлэн болсон хичээлийн жагсаалт харагдана.

2. Сонгосон
Төлбөр төлөгдөөгүй хичээл

9 бц

Нийт сонгосон багц цаг

Дарах

БИОС201 Биохими I 3 бц

Лек	Лха 16:00 - 17:30	Батжаргал.Б
Лаб	Мяг 07:40 - 12:30	Сувдмаа.Т

Хасах Баталгаажуулах >

БИОЛ303 Молекулын биологи 3 бц

Лек	Пүр 07:40 - 09:10	Баярмаа.Г
Сем	Баа 14:20 - 15:50	Оюунцэцэг.Д


Хасах Баталгаажуулах >

- **Хасах** товчийг дарснаар хичээл цуцлагдан 1-р шатанд буцан шилжих үйлдлийн аль нэгийн сонгоно.
- **Баталгаажуулах** товчийг дарснаар төлбөр төлөх хэсэгт шилжинэ.




Баталгаажуулах буюу төлбөр төлөх хэсгийн зааврыг харгалзах бүлгээс харна уу.

Баталгаажуулах буюу төлбөр төлөх хэсэг: Төлбөр төлөх хэсэг дараах хэсгүүдийг агуулна.



2.1 Баталгаажуулах хичээлийг сонгох



Баталгаажуулах хичээлийг сонгох хэсгээс дараах мэдээллийг авах болон хамаарах үйлдлийг хийнэ. Үүнд:

- Баталгаажуулах хичээлийн сонгох хэсэгт хуваарь сонгон баталгаажуулахад бэлэн болсон хичээлийн жагсаалт гарч ирнэ. Уг хэсэгт хичээлийн нэр, хичээлийн нэг багц цагийн төлбөр, нийт багц цагийн төлбөрийн мэдээллийг баганаар харуулна.
- Нийт сонгосон хичээлийн төлбөр хэсэгт төлбөр бодохоор сонгосон хичээлүүдийн нийт бодогдсон төлбөр харагдана. Хичээлийн нэрийн өмнө байрлах сонгох хэсгийг дарж **сонгож/сонгосныг цуцалж** өгснөөр тухай хичээлийн бодогдсон төлбөр нийт сонгосон хичээлийн төлбөрт **нэмэгдэн/хасагдан** бодогдоно. Энэ бүх хичээлийн төлбөрийг нэг үйлдлээр зэрэг төлөх, эсвэл сонгосон хичээлүүдээр төлөх боломжийг олгоно.
- Хоцорсон хураамж хэсэгт журмын дагуу хоцорсон бүртгэлийн хураамж тооцохоор бол тухайн тооцсон төлбөрийн дүнг харуулна.
- Нийт төлбөл зохих хэсэгт нийт сонгосон хичээлийн төлбөр болон хоцорсон бүртгэлийн хураамжийг тооцон гаргасан нийт хэрэглэгчийн төлөх төлбөр байрлана.

2.2 Төлбөр төлөх хэлбэр сонгох

Төлбөр төлөх хэлбэр сонгох хэсгээс дараах төлбөрийн мэдээллийг авах болон хамаарах үйлдлийг хийнэ. Үүнд:

- Дансны үлдэгдэл хэсэгт Суралцагчийн дансны үлдэгдэл дэх төлбөрийг мөнгөн дүнг харуулна. Суралцагч илүү төлөлттэй бол /+/, өртэй бол /-/ хэлбэрээр харагдана.

2 Төлбөрийн хэлбэр сонгох

Дансны үлдэгдэл	Дансны үлдэгдэл	₮ 1,000,000.00
	Нийт төлвөл зохих	₮ 604,200.00
	Дансны үлдэгдлээр төлөх	₮ 604,200.00

- Нийт төлбөл зохих хэсэгт баталгаажуулах хичээл сонгох хэсгээс бодогдсон нийт төлбөл зохих төлбөрийн хэмжээ харагдана. Хэрэв суралцагч дансны үлдэгдэлд өртэй буюу дутуу төлөлттэй бол тухайн төлбөрийг нийт төлбөл зохих төлбөр дээр нэмж бодохыг анхаарна уу?

2 Төлбөрийн хэлбэр сонгох

Төлвөл зохих	Дансны үлдэгдэл	₮ 1,000,000.00
	Нийт төлвөл зохих	₮ 604,200.00
	Дансны үлдэгдлээр төлөх	₮ 604,200.00

Төлбөрийг дараах 2 хэлбэрээр төлөх боломжтой:

- А. Дансны үлдэгдлээр төлөх
- Б. Онлайнаар төлөх



Төлбөр зааврыг харгалзах бүлгээс харна уу.

А. Дансны үлдэгдлээр төлөх

Дансны үлдэгдлээр төлөх хэсэгт суралцагчийн дансны үлдэгдлийн илүү төлөлтөөр төлөгдөх боломжтой төлбөрийн хэмжээ харагдана. Дансны үлдэгдэл дэх илүү төлөлтийн хэмжээ нь нийт төлбөл зохих хэмжээнээс их юм уу тэнцүү бол хичээлийг шууд **баталгаажуулж** болно.

2
Төлбөрийн хэлбэр сонгох

Дансны үлдэгдэл	₮ 1,000,000.00
Нийт төлвөл зохих	₮ 604,200.00
Дансны үлдэгдлээр төлөх	₮ 604,200.00

Дансны үлдэгдлээр баталгаажуулах

Буцах
Үргэлжлүүлэх

- Сонгосон хичээлээ дансны үлдэгдлээр баталгаажуулахын тулд **Дансны үлдэгдлээр баталгаажуулах** хэсгийг сонгон **ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ** товч дарж баталгаажуулах шаардлагатай.
- Дансны үлдэгдэл дэх илүү төлөлтийн хэмжээ нь нийт төлбөл зохих хэмжээнээс бага бол дутуу бол төлбөрийг онлайн гүйлгээний эрхтэй карт ашиглан онлайнгаар төлөх, эсвэл **Paybill үйлчилгээ** ашиглан дутуу төлбөрийг нэмж цэнэглэж болно.

PayBill үйлчилгээ: PayBill үйлчилгээгээр төлбөр төлөх гэдэг нь МУИС-ийн дансанд мөнгө шилжүүлэхийг хэлнэ. Суралцагчийн сургалтын төлбөр төлөх бүрэлдэхүүн сургуулийн данс **Данс цэнэглэх** хэсэгт байрлана. Уг хэсгээс банк, дансны дугаар, дансны нэрийг харах боломжтой бөгөөд суралцагчийн суралцаж буй бүрэлдэхүүн сургуулиас хамааран ялгаатай данс байх учир өөрийн эрхээр орж дансны мэдээллийг авна уу?

Данс цэнэглэх

Та онлайн гүйлгээний эрхтэй картаар болон -ийн дараах дансанд Paybill үйлчилгээ ашиглан төлбөрөө төлөх боломжтой. Paybill үйлчилгээгээр төлбөр төлөх заавартай [энд](#) дарж танилцана уу!

Банк	Дансны дугаар	Дансны нэр
Хаан банк	Дансы дугаар	МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
Голомт банк	Данс дугаар	МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Өөрийн сурч буй сургуулийн данс харагдана

Данс цэнэглэх Paybill үйлчилгээний давуу тал нь:

- Заавал карт ашиглах шаардлагагүй
- Банкаар үйлчлүүлэн төлбөрөө төлж болно
- Төлбөр төлөх интернет банк, смарт банк, mobile банк гэх мэт хэлбэрүүдийг ашиглаж болно
- Төлсөн төлбөр SISi дэх дансны үлдэгдэлд нэмэгдэн орно

Данс цэнэглэх Paybill үйлчилгээнд тавигдах шаардлага:

- Суралцагч бүрэлдэхүүн сургуулийнхаа Хаан болон Голомт банкны дансны дугаарыг мэддэг байх
- Суралцагч SISI системд нэвтрэх хэрэглэгчийн нэр буюу SISI ID-гаа мэддэг байх
- Аль ч хэлбэрээр гүйлгээ хийхэд гүйлгээний утга хэсэгт **SISI ID-г хамгийн эхэнд** зөвхөн латин үсгээр зай авахгүйгээр бичнэ

Жишээ нь:

Гүйлгээний утга: **14B1SAS1234**

Гүйлгээний утга: **14B1SAS1234 Овог Нэр**

/SISI ID-ний араас зай аваад дурын текст бичиж болно/

Анхааруулга:

- Данс цэнэглэх Paybill үйлчилгээг ашиглан дансаа цэнэглэсэнээр дансны үлдэгдэл төлсөн дүн нэмэгдэж орох бөгөөд **Дансны үлдэгдлээр баталгаажуулах** үйлдлийг хийж баталгаажуулалтаа хийхийг анхаарна уу?

Б. Онлайнаар төлөх

Банкны картаар төлөх хэсэгт дансны үлдэгдэл дэх илүү төлөлтийн хэмжээ нь нийт төлбөл зохих хэмжээнээс бага бол дутуу төлбөрийг картаар төлөх боломжийг олгох бөгөөд картаар төлөгдөх төлбөрийн хэмжээ харагдана.

2 Төлбөрийн хэлбэр сонгох

Дансны үлдэгдэл	155,800.3 ₮
Нийт төлвөл зохих	604,200 ₮
Дансны үлдэгдлээр төлөх	155,800.3 ₮
Банкны картаар төлөх	448,399.7 ₮

Таны төлбөрийн мэдээлэл тул сайтар шалгана уу.

⚠ Ашиглаж буй Хаан банкны карт нь E-pin, Голомт банкны карт нь E-code-той байх зайлшгүй шаардлагатай бөгөөд E-pin болон E-code кодыг **Банкны дурын ATM болон гар утасны апп-уудаас авна.**

Жич: Тухайн карт нь заавал өөрийн карт байх шаардлаггүй.

Хаан банк (карт)

Голомт банк (карт)

Голомт банк (SocialPay)

Сонгох

Буцах **Үргэлжлүүлэх** Дарах

Сургалтын төлбөрийг онлайн буюу цахим хэлбэрээр төлөхийн тулд ХААН, ГОЛОМТ банкны онлайн гүйлгээ хийх эрхтэй карт байх хэрэгтэй ба интернет гүйлгээ хийх эрхтэй и-пин код авсан байх ёстойг анхаарна уу.

ХААН банкны карт ашиглан төлбөр төлөх бол **Хаан банк (карт)**, ГОЛОМТ банкны карт ашиглан төлбөр төлөх бол **Голомт банк (карт)**, SOCIALPAY төлбөрийн үйлчилгээ ашиглах

бол **Голомт банк (Social pay)** товчин дээр дарж сонгосон банкны онлайн банкны системд шилжинэ.

Сонгосон банкны онлайн системд шилжсэний дараа банкны системийн шаардсан мэдээллүүдийг үнэн зөв бөглөж төлбөрийн гүйлгээг хийнэ.

Онлайнаар төлбөр төлж байгаа картанд алдаа банкнаас өгсөн бол тухайн картаа банкаараа шалгуулах шаардлагатай.

- **Онлайнаар төлбөр төлсөн тохиолдолд таны картнаас мөнгө хасагдаж хичээл шууд баталгаажна.**

Анхааруулга:

Систем ачаалалтай таны хичээл баталгаажуулах хүсэлтийг бүртгэн авч дарааллын дагуу баталгаажуулалтыг боловсруулалт хийж **Баталгаажуулсан** хэсэгт шилжүүлнэ. Энэ үед **“баталгаажуулалт хүлээгдэж байна”** төлөв бичигдэн дараах хэлбэрээр харагдана.

2. Сонгосон 9 бц

Төлбөр төлөгдөөгүй хичээл

СНЕМ207 Органик хими 3 бц

🔄 Баталгаажуулалт хүлээгдэж байна.

БИОС201 Биохими I 3 бц

🔄 Баталгаажуулалт хүлээгдэж байна.

3-р хэсэг. Хичээл амжилттай баталгаажсан эсэхийг шалгах

Хичээл баталгаажуулалт амжилттай болсон тохиолдолд баталгаажсан хичээл дараах байдлаар харагдана.

3. Баталгаажуулсан
Төлбөр төлөгдсөн хичээл

14 бц

Нийт баталгаажуулсан багц цаг

ARCH202 Хятадын археологи 2 бц

Цуцлах Хуваарь солих

ANTH205 Хүний остеологи 3 бц

Цуцлах Хуваарь солих

Баталгаажсан хэсэгт орсон хичээлийг баталгаажуулалтын хугацаанд **цуцлах** болон хичээлийн хуваарийг солих үйлдэл хийж болно.

Баталгаажсан хичээлүүдийн жагсаалт суралцагчийн эрхийн нүүр хэсэгт харагдана.

Судалж буй хичээлүүд

- Амьтны биологи
BIOL202 3 бц >
- Дунд шатны солонгос хэлний ханз 2
KORE311 3 бц >

Урьдчилан хуваарь харах

МУИС, ШУС-ийн хичээлд бүртгүүлэлт (Баталгаажуулалт) 2022-01-24 13:14:00-с 2022-01-29 13:12:00 -ны хооронд явагдана.

Төлөвлөгөө Биотехнологи

Дарах Урьдчилан хуваарь харах

Суралцагч өөрийн амжилттай сонгосон, сонгоогүй болон амжилттай баталгаажсан, баталгаажаагүй хүлээгдэж байгаа хичээлүүдийг нэг дор харж хичээлийн хуваарь сонголтоо төлөвлөх, сул цагуудыг харах боломжтой.

	Дав	Мяг	Лха	Пүр	Баа	Бям	Ням
07:40 - 08:25		Лаборатори Биохими I	Семинар Органик хими	Лекц Молекулын биологи	Лаборатори Органик хими		
08:25 - 09:10							
09:20 - 10:05							
10:05 - 10:50							
11:00 - 11:45			Лекц Амьтны биологи	Лекц Органик хими			
11:45 - 12:30							
12:40 - 13:25		Лаборатори Амьтны биологи					
13:25 - 14:10							
14:20 - 15:05			Семинар Дунд шатны солонгос	Семинар Дунд шатны солонгос	Семинар Молекулын биологи		
15:05 - 15:50							
16:00 - 16:45	Семинар Дунд шатны солонгос		Лекц Биохими I				
16:45 - 17:30							

Хуваарь сонгосон

Хичээлийн хуваариа сонгосон байгаа боловч баталгаажуулалт хийгээгүй байгаа

Хүлээлгийн жагсаалтанд байгаа

Хичээлийн хуваарийн суудлын тоонд багтахгүй байгаа боловч хүлээлгийн жагсаалтад бүртгүүлсэн

Амжилттай баталгаажсан

Хичээлийн хувиараа сонгон төлбөрөө төлж баталгаажсан

Баталгаажуулалт хүлээгдэж байгаа

Хичээлийн хуваариа сонгож төлбөрөө төлж баталгаажуусан боловч систем ачаалалтай байгаа үед хүлээгдэж байгаа